

# НООГДОЛ АШГИЙН ТАЛААР

Компанийн үүсгэн байгуулагчдийн нэг "Баянгол Зочид буудал" ХК нь анх байгуулагдсан цагаас хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг чухалчлан үзэж жил бүр ноогдол ашиг хуваарилж байсан. Энэхүү ноогдол ашгийн бодлого "Женко Тур Бюро"ХК–д компанид мөн хадгалагдана.

Доор "Баянгол Зочид Буудал"ХК–ийн ашиг болон ноогдол ашиг хуваарилж байсан байдлыг харуулав.




"Женко тур бюро" ХК нь өөрийн дүрэмдээ жил бүрийн цэвэр ашгийн тодорхой хувийг байнга хуваарилаж байхаар тусгаснаар хөрөнгө оруулагчдийн эрх ашгийг тодорхой хэмжээгээр хамгаалах юм.

Дүрмийн 4.4–д

Компани нь жил бүрийн цэвэр ашгийн 20–аас доошгүй хувийг хувьцаа эзэмшигчдийн ноогдол ашигт тарааж байна.

Энэхүү заалтын 20 хувь нь ноогдол ашиг хуваарилах доод хязгаар бөгөөд компанийн голлох хөрөнгө оруулагчид болон менежментийн баг энэ хэмжээг 40–50% байхаар төлөвлөж байгаа юм.